



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ДАРГА САНДАГИЙН БЯМБАЦОГТ  
ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН  
Даваагийн ЦОГТБААТАР

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон  
Утас: 26-17-89, Факс: 32-70-16

E-mail: [tsogtbaatar.d@parliament.mn](mailto:tsogtbaatar.d@parliament.mn)  
<http://www.parliament.mn>


2026. 05.15 № УМХ-03/5529  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх  
тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг миний бие санаачлан боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж өгнө үү.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ГИШҮҮН



Д.ЦОГТБААТАР



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН  
ДАРГА Л.ӨЛЗИЙСАЙХАН ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН  
Даваагийн ЦОГТБААТАР

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон  
Утас: 26-17-89, Факс: 32-70-16  
E-mail: tsogtbaatar.d@parliament.mn  
http://www.parliament.mn

2026.05.13 № 402-03/5414  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх  
тов тогтоолгох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг миний бие санаачлан боловсруулсан.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 40 дүгээр зүйлд заасны дагуу хянан үзэж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх тов тогтоож өгнө үү.

Хуулийн төслийн үзэл баримтлал, танилцуулга, хуулийн төслийг хавсаргав.

Хавсралт 7 хуудастай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ГИШҮҮН



Д.ЦОГТБААТАР

-000107

БАТЛАВ.  
УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН



Д.ЦОГТБААТАР

2026 оны тавдугаар сарын 13 өдөр

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ ДЭГИЙН  
ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН  
ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

**Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага**

**1.1.Хууль зүйн үндэслэл:**

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 7-д “төрийн санхүү, зээл, албан татвар, мөнгөний бодлого, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлого, үндсэн чиглэлийг тодорхойлж, хөгжлийн болон үндэсний аюулгүй байдлын бодлогод нийцүүлэн боловсруулсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын төсөв, түүний гүйцэтгэлийн тайланг батлах;” гэж, мөн зүйлийн 8-д “хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн биелэлтийг хянан шалгах;” асуудлыг Улсын Их Хурлын онцгой бүрэн эрх гэж тогтоосон.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 74 дүгээр зүйлээр Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланг хэлэлцэх дэгийг зохицуулсан. Энэ зүйлд зааснаар төсвийн гүйцэтгэлийг 2 үе шаттай хэлэлцэх ба нэг дэх хэлэлцүүлгээр төсвийн гүйцэтгэлийн талаар санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний илтгэл, нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаарх төрийн аудитын байгууллагын дүгнэлт, нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн талаарх Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлтийг нэгдсэн хуралдаанаар сонсож, гишүүд уг илтгэл, дүгнэлттэй холбогдуулан, асуулт асууж, үг хэлдэг.

Харин төсвийн гүйцэтгэлийн хоёр дахь хэлэлцүүлгээр Байнгын хороод мөн нам, эвслийн бүлэг төсвийн гүйцэтгэлийг хэлэлцдэг бөгөөд төсвийн гүйцэтгэлийн талаар санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний илтгэл, нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаарх аудитын дүгнэлтийг сонсож, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, төсвийн ерөнхийлөн захирагч нараас төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлантай холбоотой асуулт асууж, үг хэлж, санал, дүгнэлт гаргадаг.

Эдгээр бүх хэлэлцүүлэгт асуулт, асууж хариулт тайлбар авах хугацааг тусгайлан нарийвчлан зохицуулаагүй тул нэгдсэн хуралдаанаар болон Байнгын хорооны хуралдаанд гишүүний асуулт асуух, хариулт авах талаар бусад хуулийн төслийг хэлэлцэхээр зохицуулсан нийтлэг зохицуулалтын дагуу хэлэлцдэг.

Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын нэгдсэн чуулган болон Байнгын хороодын түвшинд зохион байгуулах явцад хугацаа хэт хязгаарлагдмал байгаа тул төсвийн зарцуулалт, үр ашиг, сахилга хариуцлагын

асуудлыг нарийн хэлэлцэх боломж хумигдмал, төсөв захирагчдын хариулт тодорхой бус үлдэх, бодит хяналт сулрах, төсвийн хяналтын парламентын үндсэн чиг үүрэг хангалтгүй хэрэгжих нөхцлийг бүрдүүлж байна.

Иймээс тухайн хэлэлцүүлгийг бодит шаардлагад нийцүүлэн хэлэлцэх, гишүүний асуулт асуух, тухайн асуултад хариулт авах хугацааг тус тус нэмэгдүүлэх зохицуулалт бүхий хуулийн төслийг боловсруулна.

## **1.2. Практик хэрэгцээ, шаардлага:**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу Байнгын хороод эрхлэх асуудлынхаа хүрээнд төсвийн гүйцэтгэлийг хэлэлцэж байгаа ч салбарын онцлогт тулгуурласан нарийвчилсан хэлэлцүүлэг зохион байгуулах, урьдчилан хүргүүлсэн асуултад холбогдох байгууллагууд бичгээр дэлгэрэнгүй хариу ирүүлснийг хуралдааны явцад тодруулж тайлбарлах боломж бараг байхгүй, хугацаа хэт богино байна. Иймээс төсвийн зарцуулалт, үр ашиг, сахилга хариуцлагын үзүүлэлтийг бодитой үнэлж дүгнэж, хэлэлцэх процессыг боловсронгуй болгосноор парламентын хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэх тогтолцоо бүрдэх юм.

### **Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

Хуулийн төслийг төсвийн гүйцэтгэлийг хэлэлцдэг зохицуулалтыг хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн боловсруулна.

Хуулийн төсөл 2 зүйлтэй. 1 дүгээр зүйлд, Байнгын хороо болон нэгдсэн хуралдаанд гишүүний асуулт асуух үндсэн хугацаа 10 минут, нэмэлт асуулт асуух хугацаа 3 минут, тайлбар хангалтгүй гэж үзвэл 2 минутаас илүүгүй хугацаагаар нэмэлт асуулт асууж, нийт 15 минутад багтаан асуулт асуух зохицуулалтыг хуулийн төсөлд тусгана. Харин хариулт авах хугацааг бусад хуулийн төсөл хэлэлцэхэд баримталдаг хугацааг 1 дахин нэмэх зохицуулалтыг тусгана. 2 дугаар зүйлд, хуулийн техникийн шинжтэй дугаар өөрчлөх зохицуулалтыг тусгана.

### **Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар**

Хуулийн төслийг хэлэлцэж баталснаар Улсын Их Хурлаар төсвийн гүйцэтгэлийг хэлэлцэхдээ төсвийн зарцуулалт, үр ашиг, сахилга хариуцлагын үзүүлэлтийг бодитой үнэлж дүгнэж хэлэлцдэг болсноор парламентын төсвийн хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэхэд нэг чухал алхам бий болно.

**Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаарх санал**

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуультай нийцсэн. Шинээр боловсруулах, өөрчлөлт оруулах хуулийн төсөл байхгүй болно.

---oOo---

## **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ ДЭГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

Монгол Улсын Үндсэн хуульд Улсын Их Хурал нь улсын төсөв, түүний гүйцэтгэлийг батлах, хуулийн биелэлтэд хяналт тавих онцгой бүрэн эрхтэй байхаар заасан. Энэ хүрээнд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 74 дүгээр зүйлээр нэгдсэн төсвийн гүйцэтгэл болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланг хэлэлцэх журмыг зохицуулж байгаа.

Гэвч өнөөдрийн мөрдөж байгаа зохицуулалтаар төсвийн гүйцэтгэлийг хэлэлцэх үеийн асуулт, хариултын хугацаа ердийн хуулийн төслийн хэлэлцүүлгийн нийтлэг хугацаагаар явагдаж байгаа нь төсвийн зарцуулалт, үр ашиг, аудитын дүгнэлт, сахилга хариуцлагын асуудлыг гүнзгий хэлэлцэхэд дутагдалтай байна.

Иймээс энэхүү хуулийн төслөөр төсвийн гүйцэтгэлийг хэлэлцэх үед гишүүний асуулт асуух болон хариулт авах хугацааг нэмэгдүүлж, тусгайлан зохицуулахаар тусгасан. Тухайлбал, Байнгын хороо болон нам, эвслийн бүлгийн түвшинд гишүүний асуулт асуух хугацааг 10 минут, асуултад хариулах хугацааг 6 минут болгож, нэмэлт тодруулга хийх боломжийг өргөжүүлж байна. Мөн нэгдсэн хуралдааны хэлэлцүүлгийн үед ч асуулт, хариултын хугацааг нэмэгдүүлж, төсвийн гүйцэтгэлийг илүү дэлгэрэнгүй, бодитой хэлэлцэх нөхцөлийг бүрдүүлэх зохицуулалтыг тусгасан.

Хуулийн төсөл батлагдсанаар Улсын Их Хурал төсвийн гүйцэтгэлд илүү үр нөлөөтэй хяналт тавих, төсвийн ерөнхийлөн захирагч нараас тодорхой, хариуцлагатай тайлбар авах, аудитын дүгнэлтийн хэрэгжилтэд бодитой анхаарал хандуулах боломж нэмэгдэнэ гэж үзэж байна.

**ХУУЛЬ САНААЧЛАГЧ**

## **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ ДЭГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА**

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 7, 8 дахь хэсэгт Улсын Их Хурал нь төрийн санхүү, төсөв, эдийн засгийн бодлогыг тодорхойлох, улсын төсөв болон түүний гүйцэтгэлийг батлах, хууль болон Улсын Их Хурлын бусад шийдвэрийн биелэлтэд хяналт тавих онцгой бүрэн эрхтэй болохыг хуульчилсан. Энэ хүрээнд төсвийн гүйцэтгэлийг хэлэлцэх үйл ажиллагаа нь парламентын хяналтын үндсэн хэрэгсэл бөгөөд төсвийн сахилга, төсвийн зарцуулалтын үр ашиг, төрийн байгууллагуудын хариуцлагыг үнэлэх чухал ач холбогдолтой юм.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 74 дүгээр зүйлээр нэгдсэн төсвийн гүйцэтгэл болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланг Улсын Их Хурлаар хэлэлцэх журмыг зохицуулсан байдаг. Уг зохицуулалтаар төсвийн гүйцэтгэлийг хоёр үе шаттай хэлэлцэхээр тогтоосон бөгөөд нэгдүгээр хэлэлцүүлгээр нэгдсэн чуулганаар санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний илтгэл, төрийн аудитын дээд байгууллагын дүгнэлт, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлтийг сонсдог. Харин хоёрдугаар хэлэлцүүлгээр Байнгын хороо болон нам, эвслийн бүлгийн түвшинд төсвийн гүйцэтгэлийг нарийвчлан хэлэлцэж, төсвийн ерөнхийлөн захирагч нараас асуулт асууж, санал, дүгнэлт гаргадаг бөгөөд эдгээрийг Төсвийн зарлагын хяналтын дэд хороо нэгтгэн нэгдсэн хуралдаанд танилцуулж, эцэст нь нэгдсэн хуралдаанаар улсын төсвийн гүйцэтгэлийг баталдаг.

Гэвч дээрх хэлэлцүүлгийн явцад гишүүний асуулт асуух, нэмэлт тодруулга хийх, хариулт авах хугацааг тусгайлан нарийвчлан зохицуулаагүй тул Дэгийн тухай хуулийн ердийн хуулийн төслийн хэлэлцүүлэгт хэрэглэдэг нийтлэг хугацааны зохицуулалтыг баримталж ирсэн. Тухайлбал, нэгдсэн хуралдаанд гишүүн 4 минутын хугацаанд асуулт асууж, 1 минутын хугацаанд нэмэлт асуулт асуух боломжтой бөгөөд хариулт 3 минут, нэмэлт тайлбар 1 минут байдаг. Мөн Байнгын хорооны хуралдаанд гишүүн 3 минутын хугацаанд асуулт асууж, 2 минутын хугацаанд нэмэлт асуулт асуух боломжтой, харин хариулт 3 минут, нэмэлт тайлбар тус бүр 2 минут байхаар зохицуулсан.

Эдгээр хугацааны зохицуулалт нь ердийн хууль тогтоомжийн төслийн хэлэлцүүлэгт тохиромжтой байж болох боловч олон их наяд төгрөгийн төсвийн зарцуулалт, төсвийн сахилга, үр ашиг, аудитын дүгнэлт, санхүүгийн тайлангийн асуудлыг гүнзгий хэлэлцэхэд хангалтгүй байгаа нөхцөл байдал үүсээд байна. Практикт төсвийн ерөнхийлөн захирагч нарын тайлбар дутуу, асуултад бүрэн хариулдаггүй, төсвийн зөрчил, үр ашиггүй зарцуулалтын асуудал тодорхойгүй үлдэх, гишүүд тодруулж асуух боломж хүрэлцдэггүй зэрэг хүндрэл байнга гарч байна. Ялангуяа Байнгын хороодын түвшинд салбарын төсвийн гүйцэтгэлийг нарийвчлан хэлэлцэхэд хугацааны хязгаарлалт бодит парламентын хяналтыг сулруулж байгаа нөхцөл байдал ажиглагдаж байна.

Иймд төсвийн гүйцэтгэлийн хэлэлцүүлгийг илүү бодитой, үр дүнтэй болгох, гишүүдийн хяналтын бүрэн эрхийг хангах, төсөв захирагчдын хариуцлагыг

нэмэгдүүлэх зорилгоор асуулт, хариултын хугацааг тусгайлан нэмэгдүүлж, нарийвчлан зохицуулах шаардлага үүссэн.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлээр Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 74 дүгээр зүйлд 74.7, 74.8 дахь хэсгийг шинээр нэмэхээр тусгасан. Шинээр нэмэх 74.7 дахь хэсгээр Байнгын хороо болон нам, эвслийн бүлгийн түвшинд явагдах төсвийн гүйцэтгэлийн хоёр дахь хэлэлцүүлгийн үед гишүүний асуулт асуух болон хариулт авах хугацааг тусгайлан зохицуулсан. Тухайлбал, гишүүн үндсэн асуултаа 10 минутаас илүүгүй хугацаанд асуух, нэмэлт асуултыг 3 минутаас илүүгүй хугацаанд асуух, хариулт, тайлбар хангалтгүй гэж үзвэл 2 минутаас илүүгүй хугацаагаар дахин тодруулга хийх, гишүүний асуултад 6 минутаас илүүгүй хугацаанд хариулах, нэмэлт тайлбарыг 2 хүртэл удаа тус бүр 4 минутаас илүүгүй хугацаанд өгөхөөр зохицуулсан.

Мөн шинээр нэмэх 74.8 дахь хэсгээр нэгдсэн чуулганы нэг болон хоёр дахь хэлэлцүүлгийн үед мөрдөх асуулт, хариултын хугацааг тусгайлан тогтоож өгсөн. Тухайлбал, гишүүний асуулт асуух үндсэн хугацаа 10 минут, нэмэлт асуулт 3 минут, дахин тодруулах асуулт 2 минут, хариулт өгөх хугацаа 6 минут, нэмэлт тайлбар 2 минутаас илүүгүй хугацаатай байхаар тусгасан.

Эдгээр зохицуулалтыг одоогийн мөрдөгдөж буй хугацааны зохицуулалттай харьцуулахад асуулт асуух болон хариулт авах хугацаа мэдэгдэхүйц нэмэгдэж байгаа бөгөөд ингэснээр төсвийн гүйцэтгэл, аудитын дүгнэлт, төсвийн сахилга, үр ашигтай холбоотой асуудлыг илүү гүнзгий, дэлгэрэнгүй хэлэлцэх боломж бүрдэх юм. Түүнчлэн төсвийн гүйцэтгэлийн хэлэлцүүлгийг ердийн хууль тогтоомжийн төслийн хэлэлцүүлгээс ялгамжтай авч үзэж, парламентын хяналтын онцгой ажиллагааны нэг хэлбэр гэдгийг хууль зүйн хувьд тодотгож буй ач холбогдолтой.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлээр Дэгийн тухай хуулийн одоогийн 74.7 дахь хэсгийн дугаарыг "74.9" болгон өөрчлөх техникийн шинжтэй зохицуулалтыг тусгасан. Учир нь 74.7, 74.8 гэсэн шинэ хэсгүүд нэмэгдэж байгаа тул өмнө нь хүчин төгөлдөр үйлчилж байсан 74.7 дахь хэсгийн дугаарлалт давхцах нөхцөл үүсэж байгаа юм. Энэ нь зөвхөн хуулийн бүтэц, дэс дарааллыг алдагдуулахгүй байх техникийн өөрчлөлт бөгөөд агуулгын хувьд шинэ зохицуулалт үүсгэхгүй.

Хуулийн төсөл батлагдсанаар Улсын Их Хурал төсвийн гүйцэтгэлд илүү бодитой, үр дүнтэй хяналт тавих боломж нэмэгдэнэ. Төсвийн ерөнхийлөн захирагчид гишүүдийн асуултад илүү дэлгэрэнгүй, тодорхой хариулт өгөх шаардлага үүсэж, төсвийн сахилга, тайлагналын чанар дээшлэх нөхцөл бүрдэх юм. Мөн төрийн аудитын байгууллагын дүгнэлттэй холбоотой асуудлыг илүү нарийвчлан тодруулах боломж нэмэгдэж, аудитын зөвлөмжийн хэрэгжилтэд бодит анхаарал хандуулах нөхцөл бүрдэнэ. Түүнчлэн төсвийн зарцуулалттай холбоотой асуудлыг илүү нээлттэй, дэлгэрэнгүй хэлэлцэх нь төсвийн үйл ажиллагааны ил тод байдлыг нэмэгдүүлж, парламентын хяналтын үр нөлөөнд иргэдийн итгэх итгэлийг бэхжүүлэх ач холбогдолтой.

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Төсвийн тухай хууль, Төрийн аудитын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль болон Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуультай

нийцэж байгаа бөгөөд уг хуулийн төслийг баталсантай холбогдуулан бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлага үүсэхгүй.

Иймд энэхүү хуулийн төсөл нь парламентын төсвийн хяналтыг бодитой хэрэгжүүлэх, төсвийн ил тод байдал, хариуцлагыг сайжруулах, гишүүдийн хяналтын бүрэн эрхийг үр нөлөөтэй хэрэгжүүлэхэд чиглэсэн ач холбогдолтой зохицуулалт болно.

## ХУУЛЬ САНААЧЛАГЧ

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2026 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ  
ДЭГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ  
ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 74 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 74.7, 74.8 дахь хэсэг нэмсүгэй:

"74.7. Энэ хуулийн 74.4.2-т заасны дагуу гишүүний асуулт асуух хугацаа 10 минутаас илүүгүй, нэмэлт асуулт асуух хугацаа 3 минутаас илүүгүй байх бөгөөд хариулт, тайлбар хангалтгүй гэж тухайн гишүүн үзвэл 2 минутаас илүүгүй хугацаагаар нэмэлт асуулт асууж, тайлбар авч болно. Гишүүний асуултад хариулах хугацаа 6 минутаас илүүгүй, нэмэлт тайлбар өгөх хугацаа 2 хүртэл удаа тус бүр 4 минутаас илүүгүй байна.

74.8. Энэ хуулийн 74.5, 74.6-д заасны дагуу гишүүний асуулт асуух хугацаа 10 минутаас илүүгүй, нэмэлт асуулт асуух хугацаа 3 минутаас илүүгүй байх бөгөөд хариулт, тайлбар хангалтгүй гэж тухайн гишүүн үзвэл 2 минутаас илүүгүй хугацаагаар нэмэлт асуулт асууж, тайлбар авч болно. Гишүүний асуултад хариулах хугацаа 6 минутаас илүүгүй, нэмэлт тайлбар өгөх хугацаа 2 минутаас илүүгүй байна."

**2 дугаар зүйл.** Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 74 дүгээр зүйлийн 74.7 дахь хэсгийн дугаарыг "74.9" гэж өөрчилсүгэй.

Гарын үсэг